



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД
Б.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2019.04.02 № 01/2737
танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх
тухай

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын удирдах албан тушаалтан нар нь бусдад давуу байдал бий болгон, хээл хахууль авч, аж ахуйн нэгжүүдэд улс хоорондын ачаа тээвэр эрхлэх "С" зөвшөөрлийг батлагдсан тооноос хэтрүүлж олгосон, албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж системд бүртгэлгүй автотээврийн хэрэгслийг бүртгэсэн, тээврийн хэрэгслийн хуурамч мэдээллийг мэдээллийн санд оруулсан зэрэг гэмт хэрэгт холбогдон шалгагдаж шүүхээр ял шийтгүүлсэн байна.

Авлигатай тэмцэх газраас дээрх гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцлийг арилгах мөрдөгчийн мэдэгдлийг удаа дараа хүргүүлсэн боловч биелэлт хангалтгүй байна.

Авлигын гэмт хэрэг дахин давтан гаргахаас урьдчилан сэргийлж, Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-ын авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцаж тусгай зөвшөөрөл дагасан авлигын эрсдлийг бууруулах, улс хоорондын ачаа тээвэр эрхлэх "С" зөвшөөрөл олгох үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох зорилгоор Зам, тээврийн хөгжлийн яам, Автотээврийн үндэсний төв, төрийн бус байгууллагуудын болон улс хооронд ачаа тээвэрлэдэг аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл оролцсон "Улс хоорондын байнгын ачаа тээвэр эрхлэх "С" зөвшөөрөл олгох үйл ажиллагаан дахь хүндрэл бэрхшээл, авлига гарах нөхцөлийг бууруулах нь" сэдэвт хэлэлцүүлгийг 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Авлигатай тэмцэх газрын "Олон нийтийн төв"-д хамтран зохион байгууллаа.

Хэлэлцүүлгийн үеэр оролцогч талууд авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэрэг, хүнд суртал, чирэгдэл үүсэх гол шалтгаан, нөхцөлийг хөндөн ярилцсан бөгөөд үүнтэй уялдуулан авлигын эрсдэл үүсгэж буй шалтгаан, нөхцөлийг арилгах зөвлөмжийг Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д заасны дагуу хүргүүлж байна.

Зам, тээврийн хөгжлийн яам, Авто тээврийн үндэсний төв хамтран Зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг авч, дүнг 2019 оны 6 дугаар сарын 01-ний дотор хариу ирүүлнэ үү.

Хавсралт: Зөвлөмж 5 хуудас.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР



Х.ЭНХЖАРГАЛ

C:\DOCUMENTS\ALBANBICHIG\A4

0005037



#1. ЗӨВЛӨМЖ

Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах;

Эрх зүйн үндэслэл:

- Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5;
Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8

#2. ЗӨВЛӨМЖ

Зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгжид тодорхой хугацаанд хариу өгдөг болох, зөвшөөрөл өгөх боломжгүй бол шалтгааныг тодорхой дурьдаж хариуг өгч байх;

Эрх зүйн үндэслэл:

- Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11;
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6;

ЗӨВЛӨМЖ

Улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлтэд "С" төрлийн зөвшөөрөл олгох бичгийг мэдээлэл ойр томоохон ачаа тээврийн компанид олгодог. Үндэсний жижиг аж ахуйн нэгжүүд тус зөвшөөрлийн бичгийг авахад хүндрэлтэй талаар АТГ-т зохион байгуулсан хэлэлцүүлэгт оролцсон аж ахуйн нэгжүүд онцолж байна.

Иймд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмын нээлттэй байдлыг хангаж албан ёсны цахим хуудсанд байршуулах;

Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, авто машины дугаар, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах;

Тухайн жил, улиралд олгох зөвшөөрлийн дээд хэмжээ болон зөвшөөрөл олгохтой холбоотой бусад шинэ зохицуулалтыг тухай бүр мэдээлэх;

Зөвшөөрлийн бичиг хүссэн аж ахуйн нэгж, компаниудад хариу өгдөггүй, ямар үндэслэл шалтгаанаар татгалзаж байгаа нь тодорхойгүй зэрэг хүндрэлүүд гардаг.

Иймээс зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгжид аль болох түргэн шуурхай хариу өгөх, хүсэлт гаргагчид өгөх боломжгүй бол шалтгааныг тодорхой бичиж түргэн шуурхай, ойлгомжтой байдлаар хариу өгөх ажлыг зохион байгуулах;

-Зөвшөөрлийн бичгийг улирлын эхний 15-ны дотор шийдвэрлэх гэж зааж өгсөн нь цаг хугацааны хувьд давчуу учир сарын өмнө, материалыг авдаг болгох;

- "С" зөвшөөрлийг өөр авто машинд ашиглаж зөвшөөрөлгүй тээврийн хэрэгсэл хил нэвтэрч байна. "С" зөвшөөрөл олгох бичигт авто машины арлын дугаарын мэдээллийг оруулах.



Аж ахуйн нэгжүүдийн зүгээс шаардлагагүй материалыг олон дахин гаргаж өгдөг. Өмнөх зөвшөөрөл авахад бүрдүүлсэн материалыг дараа улиралд зөвшөөрөл авахад дахин бүрдүүлж байгаа нь хүндрэлтэй байгаа талаар дурьдсан.

Аж ахуйн нэгжүүд уурхайд бүрдүүлж өгсөн материалыг АТҮТ-д дахин гаргаж өгч байгаад дүгнэлт хийж, АТҮТ-Уурхай хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах ажлыг эхлүүлэх;

Зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалын жагсаалтыг судалж, шаардлагагүй баримт материалыг цөөлөх ажлыг зохион байгуулах;

#3 ЗӨВЛӨМЖ

Зөвшөөрөл авахад гарч буй хүнд суртал, чирэгдлийг арилгах зорилгоор бүрдүүлэх материалын жагсаалтыг цөөлөх, цахим хэлбэрээр авах ажлыг эрчимжүүлэх;

Эрх зүйн үндэслэл:

- Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11, 6.1.12;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1

Гашуун сухайтын тээвэрлэлтэд Гаалийн байгууллага Авто тээврийн үндэсний төвийн дунд мэдээлэлгүй байснаас 2017 оны 10 сараас 2018 оны 11 сар хүртэл "Гаалийн байгууллагаас итгэмжлэгсэн тээвэрлэгч"-ийн эрх өгөөгүй байна.

Иймд төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцох ажлыг сайжруулж, автомат хяналтын системийг нэвтрүүлэх боломжийг судалж, тээвэрлэгч нарт түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх;

#4 ЗӨВЛӨМЖ

Хамтран ажилладаг төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцох ажлыг сайжруулах;

Эрх зүйн үндэслэл:

- Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6



#5. ЗӨВЛӨМЖ

Ачаа тээврийн үйл ажиллагаа явуулахад гарч буй хүндрэл бэрхшээлийг салбарын болон холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэх;

Эрх зүйн үндэслэл:

- Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12;

“Улс хоорондын байнгын ачаа тээвэр эрхлэх “С” зөвшөөрөл олгох үйл ажиллагаан дахь хүндрэл бэрхшээл, авлига гарах нөхцөлийг бууруулах нь” сэдэвт хэлэлцүүлэгт оролцогч нараас салбарын яам, агентлаг тээвэрлэгч аж ахуйн нэгжид тулгамдаж буй асуудлуудад зохицуулалт хийх шаардлагатай талаар дурьдсан.

Тухайлбал:

- Улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлтэд “С” зөвшөөрөл олгох үйл ажиллагааг Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ чиг үүргийн дагуу зохион байгуулж байгаа бөгөөд салбарын яам дахин хянахаар ажлын хэсэг байгуулах нь шат дамжлагыг нэмэгдүүлж, хүнд суртал, чирэгдэл бий болгох эрсдэл үүсч байх тул үүнд анхаарч оновчтой шийдвэрлэх;

-БНХАУ-ын талд авто машины бүрдүүлэлт хийхгүй, 3-4 хоног хүлээлгэх зэрэг хүндрэлийг арилгах талаар судалж, шийдвэрлэх;

-Татварын хуулиас шалтгаалж Монгол компаниуд жолоочийн цалинг тогтсон хугацаанд өгдөггүй учраас жолооч нар хятад эзэнтэй компанид ажилладаг, хятад компани тээврийн хэрэгсэл техникийн бүрэн бус байдал дутмаг байдаг, осол аваарт их орох тохиолдол гардаг тул техникийн хяналтыг сайжруулах;

-Аж ахуйн нэгж байгууллагуудад засварын газар байгуулах газар олддоггүй. Өмнөговь аймгийн Ханбогд суманд газар авахад 1 га газар 50 сая төгрөг, 2 га газар авахад 100 сая төгрөгөөр зарна гэдэг тул газар авч, засварын төв байгуулахад хүндрэлтэй, Аж ахуйн нэгж бүр тус тусдаа засварын төв байгуулах боломжгүй тул хамтарсан засварын төв байгуулах боломж олгож олгох;



#6. ЗӨВЛӨМЖ

“Улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлтэд С зөвшөөрлийн бичиг олгох журам”-ын төслийн зарим зүйл заалтыг өөрчлөн найруулж, ойлголтын зөрүүг арилгах;

Эрх зүйн үндэслэл:

- Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10;

Журмын төсөлд ойлгомжгүй, тухайлан зохицуулаагүй, ерөнхий агуулгатай хэд хэдэн зүйл байна. Тухайлбал;

-Журмын төслийн 3 дугаар зүйлийн 3.5-д “...тээврийн хэрэгслийн бүртгэлийг шалган тухайн байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчид олгоно.” гэж оруулсан байна. Энэ хэсэгт итгэмжлэгдсэн төлөөлөгч гэж хэнийг хэлж байгааг журамд тодорхой болгох;

- “С” зөвшөөрөл олгох журмын төсөлд Олон улсын тээвэр, Улс хоорондын тээвэр гэж ялгаатай нэр томъёо орсныг хууль зүйн талаас нэг болгох;

- Аж ахуйн нэгж, жолооч нарын мэдээллийг багтаасан QR кодыг зөвшөөрөл олгох гэрчилгээнд тусгаж өгсөн боловч “С” зөвшөөрөл олгох журмын төсөлд энэ талаарх зохицуулалтыг оруулаагүй тул журмын төсөлд тусгах;

- Журмын төслийн 2.2, 2.3, 3.7, 3.8.1, 3.9.1-д уурхай эзэмшигч аж ахуйн нэгж байгууллага, уурхай эзэмшигч тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагын хоорондын тээвэрлэлтийн гэрээнд үндэслэн гэж хоёр агуулгатай орсон;

-Журмын 3 дугаар зүйлийн 3.10.4-д ноцтой осол гаргасан бол зөвшөөрөл олгохгүй гэсэн зохицуулалтын эсрэг байр сууртай байгааг оролцогч нараас илэрхийлсэн. Гашуун сухайт авто замд гардаг авто ослын гол шалтгааны нэг нь жолооч амралтгүй ажиллах, техникийн бүрэн бус байдлын улмаас осол гардаг талаар оролцогч талууд санал нэг байсан тул энэ талаарх зохицуулалтыг нэмэх талаар судлах нь зүйтэй байна.



Хэлэлцүүлгийн үеэр Автотээврийн үндэсний төвөөс Улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлтэд "С" зөвшөөрлийн бичиг олгох журмыг ганц Гашуун сухайт боомтод үйлчилхээр танилцуулсан.

Улсын хэмжээнд нийт ажиллаж байгаа бусад боомтод үйлчилэх эсэхийг тодорхой болгож, тээвэрлэлт эрхэлдэг бусад боомтоор үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжээс санал авах нь зүйтэй байна.

#7. ЗӨВЛӨМЖ

Улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлтэд "С" зөвшөөрлийн бичиг олгох журмыг нэгдсэн байдлаар бүх боомтод үйлчилэхээр зохицуулах, журмын төсөлд санал авах;

Эрх зүйн үндэслэл:

- Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12;

Одоогоор Авлигатай тэмцэх газарт "С" зөвшөөрөлтэй холбоотой хоёр эрүүгийн хэрэг шалгагдаж, нэг хэрэг шүүхээр бүрэн шийдэгдээд байна.

Авто тээврийн үндэсний төв дотоод хяналтыг сайжруулж, авлига гарах шалтгаан, нөхцөлийг судалж арилгах ажлыг үр дүнтэй зохион байгуулахгүй бол цаашид албан тушаалтанууд эрсдэлд орох магадлалтай байна.

Иймд "С" зөвшөөрөл олгох журмын хэрэгжилтэд хяналт тавих тусгайлсан төлөвлөгөө гаргаж дараахь ажлуудыг тусгах нь зүйтэй. Тухайлбал;

Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах;

Эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээг гүйцэтгэх албан тушаалтан, ажилтны үйл ажиллагааг хянах нөхцөл боломжийг бүрдүүлэх;

#8. ЗӨВЛӨМЖ

Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэхэд анхаарах, "С" зөвшөөрөл олгох журмын хэрэгжилтэд хяналт тавих тусгайлсан төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтэд хяналт тавих;

Эрх зүйн үндэслэл:

- Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12;